

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ БАРУУН-УРТ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.04.30

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Орон нутгийн зарим нисэх буудлуудын үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит, хяналт шалгалт хийх 06/21 дугаартай удирдамжийн дагуу ИНЕГ-ын харьяа Сүхбаатар аймаг дахь Баруун-Урт нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор А.Мөнх-Эрдэнэ 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг зайнаас хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Сүхбаатар аймаг дахь Баруун-Урт нисэх буудлын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Сүхбаатар аймаг дахь нисэх буудлын 13 ажилтны албан тушаалын тодорхойлолтод тавигдсан шаардлагуудыг хувийн хэрэг, төгссөн сургууль, сургалтуудын үндсэн гэрчилгээтэй нь тулган үзэхэд 2 ажилтан нь боловсрол мэргэжлийн болон туршлагын шаардлага хангаагүй байна.

Албан хэрэг хөтлөх мэдлэг хангалтгүй байдал болон ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалан нисэх буудлын даргын гаргасан тушаалууд нь Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын шаардлагыг хангаагүй байна.

Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын 2.4.5.1, 2.4.5.3-д заасан заалт мөн Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу гэрээ байгуулахдаа дугаарлаагүй, гэрээний бүртгэл хяналтыг хөтлөхгүй байна.

ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 2.3.3-д заасны дагуу цагийн бүртгэлийг үндэслэж цалин хөлсийг тооцож олгоогүй урьдчилгаа цалинг өндөр дүнгээр олгосон. Цагийн бүртгэл хөтлөлтийг хангалтгүй хэрэгжүүлсэн.

Тус нисэх буудал нь 2020 оны 04 дүгээр улирлаас 2021 оны 01 дүгээр улиралд байршуулсан Шилэн дансны мэдээллийг шалгахад хугацаа хоцроосон, алдаатай мэдээлэл байршуулсан, мэдээлэл байршуулаагүй зэрэг зөрчлүүд гарсан байна. Өмнөх дотоод аудитаар өгсөн Шилэн дансны мэдээлэл байршуулах тухай зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй буюу зөрчил давтан гарсаар байна.

Нисэх буудлын даргын 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр баталсан “Баруун-Урт нисэх буудлын Дотоод хяналтын журам”-аа хангалттай хэрэгжүүлээгүй, эрсдэлийн үнэлгээ хийгээгүй, олон хяналт шалгалтыг нэгтгэн нэг тайлан бичсэн ба нисэх буудлын дарга танилцаагүй буюу гарын үсэг зураагүй байна.

ДАА-аас ИНЕГ-ын даргын баталсан 26/20 дугаартай удирдамжийн дагуу 2020 оны 10 дугаар сард хийгдсэн дотоод аудит, хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 80% буюу бүрэн хэрэгжээгүй байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус нисэх буудалд 8 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА